



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 277

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.3, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай” Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Хилийн боомтын дэд бүтэц” төслийн хүрээнд хийгдэх ажлын бэлтгэл хангах зайлшгүй шаардлагыг харгалзан Замын-Үүд чөлөөт бүсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 129,230,100.00 (нэг зуун хорин есөн сая хоёр зуун гучин мянга нэг зуун) төгрөгийн балансын үнэ, 13,461,468.00 (арван гурван сая дөрвөн зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун жаран найман) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг буулгаж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч И.Батнасан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг буулгаж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Үл хөдлөх хөрөнгийг буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албаны зориулалтаас өөр хэлбэрээр ашиглахгүй байх;

2.4. Үл хөдлөх хөрөнгийг буулгаж, ашиглаж болох эд зүйлийг ялган тоолж, худалдан борлуулах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

0000608
C:\2019.07.16 15r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалт
2019 оны 07 дугаар сарын 27
2019 оны 07 дугаар тогтоол



**"Замын-Үүд" чөлөөт бүсийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах үл хөдлөх хөрөнгийн жагсаалт**

Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Ү
алалтын хашаа	2008.10.15	м2	22348	5,782.62	129,230,100.00	13,461,468.00	1
Нийт дүн					129,230,100.00 (нэг зуун хорин есөн сая хоёр зуун гучин мянга нэг зуун)	13,461,468.00 (арван гурван сая дөрвөн зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун жаран найман)	11 (нэ д жа мя зуун